

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/38

Арвайхээр сум

Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тусгай  
зөвшөөрөл шинээр олгох, сунгах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2,19.3,19.14, 19.15, 19.18, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14,15, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны а/100 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичигт тавигдах шаардлага”, 2023 оны а/383 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын ажиллах журам”-ын 5.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой ажлыг гүйцэтгэх ажлын албаны ирүүлсэн санал, дүгнэлт, Эрүүл мэнд эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн шийдвэрийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах нэр бүхий 3 байгууллага, аж ахуйн нэгжийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс ( Я. Жаргал ) -т үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭГТГЭГЧ  Н.ОЮУНТУЯА



Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 08 дугаар сарын 30-ны  
өдрийн 07 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ НЭР БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН  
НЭГЖИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Сунгах хугацаа	Хүчинтэй байх хугацаа/ огноо
1	"Газарчин-Хужирт" сувилал, РД-2563886 №ЭХ/13/19/32	Рашаан сувилал	Хужирт сум, Шивээт, 4-р баг	сунгах	5 жил	2029 оны 07 дугаар сарын 18 ны өдрийг хүртэл
2	Тарагт сумын нийтийн үйлчилгээтэй эмийн сан РД-3556786 №ЭХ-13/19/54	Эм, эмнэлгийн хэрэгсэл, гоо сайхны худалдаа	Тарагт сум, Өлзийт хороолол	сунгах	5 жил	2029 оны 07 дугаар сарын 22 ны өдрийг хүртэл
3	Хайрхандулаан суманд үйл ажиллагаа явуулдаг "Ганга идэр ХХК -ны "Ганга идэр" хувийн эмийн сан РД-3556891 №ЭХ-13/19/55	Эмийн сангийн үйлчилгээ	Хайрхандулаан сум, 6-р баг	сунгах	5 жил	2029 оны 07 дугаар сарын 22 ны өдрийг хүртэл